



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2024-2027 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Улаанбаатар хот
2024**

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	2
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	5
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	8
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	8
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	8
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	12
ДОЛОО. БАРИМТЛАХ ЗАРЧИМ.....	13
НАЙМ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН.....	14
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	14
ЕС.САЛБАР, ХАМТРАГЧ ТАЛ	15

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 22 дугаар, Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” байгуулагдаж, Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор хяналтын чиг үүрэг нэмэгдэж, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын цогц үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрөөс Засгийн Газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Улсын Их хурлын 2020 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн бүдүүвч”-ийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг батлагдаж, 6 газар, 2 хэлтэс, эм шинжлэх лабораторид нийт 132 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 4025 эм бүртгэгдснээс 19.8% нь үндэсний үйлдвэрийн, 80.2% импортын эм эзэлж байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд 2006 оноос эхлэн “LICEMED” цахим программ, тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оноос Tzmoh.gov.mn цахим системийг ашиглаж, импортын болон үндэсний үйлдвэрийн эмийн савлалтын зураг, эмийн гаж нөлөө, импорт, экспортын лиценз, тусгай зөвшөөрөлтэй байгууллага, ханган нийлүүлэх байгууллагын жилийн борлуулалтын тайлан зэрэг мэдээллийн сан үүсгэсэн. Эмийн бүртгэлийн баримт бичиг болон импорт экспортын лиценз, тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оноос И-Монголиа системээр хүлээн авч, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, ил тод болгон ажиллаж байна.

Эмийг зах зээлд гарсны дараа чанар, аюулгүй байдлыг тандан судлаж, зах зээлээс хуурамч, стандартын бус, бүртгэлгүй эм, гаж нөлөөний дохиог илрүүлэн мэдээлэл, солилцох, эрсдлээс эрт сэрэмжлүүлэх, шаардлагатай тохиолдолд зах зээлээс эргүүлэн татах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Нянгийн эсрэг эмийн 2020 оны хэрэглээнд хийсэн судалгаагаар манай улс өдрийн тунлагдсан тооцоогоор 1000 хүн ам/өдөрт 40.48 хэрэглээтэй байсан. Энэ нь өмнөх онуудтай харьцуулахад буурсан боловч нийт хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн тал хувийг тарилгаар хэрэглэсэн нь бусад улсуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан. АШУҮИС-ийн Эм зүйн сургуультай хамтран 2021 онд иргэдийн дунд “Эмийн зохистой хэрэглээний мэдлэг, хандлага, дадал”-ыг судлахад 3 хүн тутмын 1 нь мэдлэгтэй, 5 хүн тутмын 1 нь зөв дадалтай байв.

Монгол Улсад 43 эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, протез, биобэлдмэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх үйлдвэр байгаагаас 26

үйлдвэр нь эм үйлдвэрлэж, 9 эмийн үйлдвэр “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг нэвтрүүлж GMP-ийн батламж авчээ.

Монгол Улсын Үндэсний Фармакопей нь эмэнд тавих шаардлага, чанарын үзүүлэлт болон тэдгээрийг шинжлэх арга, аргачлалыг заасан зайлшгүй мөрдөгдөх стандартын эмхэтгэл бөгөөд Фармакопейн шаардлагыг эмийн чанарыг шалгахад мөрдөж байна. Фармакопейд үнэлгээ хийж, шинэчлэн сайжруулснаар эмийн чанар, аюулгүй байдал, хадгалалт, түгээлтэд тавих хяналтыг сайжруулах чухал ач холбогдолтой бөгөөд 2023 онд үндэсний фармакопейн анхдугаар хэвлэлд үнэлгээ хийгээд байна.

Хэмжил зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа 13 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийж 2023 онд 169 эрүүл мэндийн байгууллагын 1624 эмнэлгийн тоног төхөөрөмжийг шалгалт тохируулгад хамруулснаас 222 буюу 11,6 хувь нь тэнцээгүй. Шалгалт тохируулгын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд баталгаатай эмнэлгийн тоног төхөөрөмжөөр үйлчлэх боломж бүрдэнэ. Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээлэл хангалтгүйгээс нотолгоонд суурилан шийдвэр гаргах, хөрөнгийн төлөвлөлт хийх боломжгүй байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2022 онд 154 эмнэлэг, 139 эм ханган нийлүүлэх байгууллага, 2023 онд 250 эмнэлэг, 370 эм ханган нийлүүлэх байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. 2023 оны 5 дугаар сараас зөрчлийн хянан шалгах чиг үүрэг тодорхой болсон.

Улсын төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж 2022 оны жилийн эцсийн байдлаар 116 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл цахим дэлгүүрт байршуулсан бол 2023 оны байдлаар нийт 143 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршуулж, өмнөх оноос 23 хувиар нэмэгдэж, 109 нэрийн эм, 9 эмнэлгийн хэрэгсэл, 25 өндөр өртөг бүхий эмнэлгийн хэрэгсэл цахим дэлгүүрт байршсан.

Цар тахал, олон улсын нөхцөл байдалтай холбогдуулан эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эдийн үнийн өсөлт, тээвэрлэлт, хадгалалтын зардлын нэмэгдэл, инфляци, ханшийн өөрчлөлт, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлын нэмэгдлийг дагаж эмийн үнэ өсөж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн хугацаанд тасралтгүй импорт хийгдсэн 553 нэрийн зайлшгүй шаардлагатай эмийн үйлдвэрлэгчийн үнэ 2020-2022 онд 254 хүртэлх хувиар нэмэгдсэн байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг үндэслэн зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл тогтоож, 590 нэр төрлийн эмийг 30-100 хувийн хөнгөлөлттэй олгож байна.

Цаашид нэн чухал болон өнчин эмийн нөөц, хангамжид тусгайлсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг боловсронгуй

болгож, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд эрх зүйн орчны болон зохион байгуулалт, цахимжуулалтын шинэчлэл зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2024-2027 оны хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”, Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 216 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал болон бусад холбогдох шийдвэр хууль эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсрууллаа.

Энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр байгууллагын хөгжлийн ирээдүйн хандлага, тэргүүлэх чиглэл тодорхой болж, өөрчлөгдөн буй гадаад орчны нөхцөл байдалд үйл ажиллагаагаа нийцүүлэх боломж бүрдэж, удирдлага, зохион байгуулалтаа тасралтгүй сайжруулж, ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлж, гадаад, дотоод түншлэл, хамтын ажиллагаа өргөжин тэлж, байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэж үзсэн болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Чиг үүргийг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу Эрүүл мэндийн салбарын болон Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүрэгт үндэслэн мандатын шинжилгээ хийсэн.

Мандатын шинжилгээгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа нийт 118 хууль, 14 олон улсын гэрээ, конвенцын хүрээнд ажиллаж байна. Үүнээс тус газрын чиг үүрэгт шууд хамаарах 10, төрийн захиргааны байгууллагад нийтлэгээр мөрдөн ажиллах 10 хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явж байна.

Хүснэгт 1. Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар нийтлэг мөрдөгдөж байгаа хуулийн тоо

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		118
Үүнээс:	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалттай холбоотой хуулийн тоо-10	Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн (БИБ)-ний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, зар сурталчилгааны зөвшөөрөл, эмзүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг учраас 1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 2.Эрүүл мэндийн тухай хууль 3.Төрийн хяналт шалгалтын тухай хууль 4. Зар сурталчилгааны тухай хууль 5.Хэмжил зүйн тухай хууль 6.Зөвшөөрлийн тухай хууль 7.Зөрчлийн тухай хууль 8.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 9. Стандарт, тохирлын тухай хууль 10. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо-10	1.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль 2.Захиргааны ерөнхий хууль 3.Төрийн албаны тухай хууль 4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 6.Кибер аюулгүй байдлын тухай хууль 7.Төрийн болон албаны нууцын тухай 8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 9.Төсвийн тухай хууль 10.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж

Хүснэгт 2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын ерөнхий болон үндсэн чиг үүрэг

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага
Нэг. Ерөнхий чиг үүрэг: Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах			
1.1	Эмийн зохицуулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журам, стандарт боловсруулах, шинэчлэх хэрэгжилтийг хангах ажлын зохион байгуулалт	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах манлайлал, чадавхийг бэхжүүлэх	ҮАБЗ, УИХ, ЗГ, ЗГХЭГ, ЭМЯ
		Дотоод, гадаадын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЭМЯ, бусад төрийн болон ТББ, ОУБ
1.2	Зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг нэмэгдүүлж, үнийн ил тод байдал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа	Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, хүртээмжид дүн шинжилгээ хийх, үнийн мэдээллээр хангах	ЭМЯ, ШӨХТГ, ГЕГ, ЭМДЕГ, эм хангамжийн байгууллага (ЭХБ), ЭМБ-ууд
		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц хангамжийг зохицуулах	ЭМЯ, ЭМБ-ууд, ЭХБ, ОБЕГ, ШӨХТГ
		Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч нарыг чадавхжуулах,	ЭМЯ, ЭМБ, Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллага (ЭТТХНБ), ТББ, Мэргэжлийн зөвлөл
		Эмнэлгийн тоног төхөөрөмж, эрүүл мэндийн байгууллагын дэд бүтцийн судалгаа хийх	ЭМЯ, ЭМБ, ЭТТХНБ, ТББ, Мэргэжлийн зөвлөл
Хоёр. Ерөнхий чиг үүрэг: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгааг хангах			
2.1	Эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, худалдах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх явуулах тусгай зөвшөөрөл, импорт, экспортын лицензийн зохицуулалт	Эм зүйн тусламж үйлчилгээнд мөрдүүлэх зохистой дадлын стандартыг боловсруулах, хэрэгжилтийг хангах (GMP, GLP, GDP, GSP, GCP, GPP)	ЭМБ, ЭХБ, Мэргэжлийн зөвлөл, ХЭЗ ба салбар зөвлөл, ТББ
		Холбогдох мэргэжлийн зөвлөл, төрөлжсөн төв болон төрийн бус байгууллагатай хамтарч, мэргэшсэн шинжээчдийг ажиллуулах	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг, ТББ
		Тайлан, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, цахим тогтолцооны тогтвортой байдлыг хангах	Мэдээллийн технологийн байгууллага (МТБ), ЭМБ, Мэргэжлийн ТББ

2.2	Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-нийг зах зээлд гаргах зөвшөөрлийн зохицуулалт	Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-нийг улсын бүртгэлд бүртгэх, хугацааг сунгах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах үйл ажиллагааг зохион байгуулах	ХЭЗ, ЭХБ, Гадаадын үйлдвэрлэгч
		Зах зээлд гаргах зөвшөөрлийн зохицуулалттай холбоотой дүрэм, журам, Стандарт ажиллагааны заавар (CA3) гарын авлага боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, тасралтгүй сайжруулах	ЭХБ, Мэргэжлийн нийгэмлэг, ТББ, ОУБ
		Бүртгэлийн шинжээчдийн чадавхийг тасралтгүй сайжруулах	ОУБ, Сургалт, судалгааны байгууллага, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг, ТББ
		Бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх цахим мэдээний сангийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг сайжруулах	ОУБ, МТБ-ууд
Гурав. Ерөнхий чиг үүрэг: Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах			
3.1	Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний зах зээл дэх аюулгүй байдлын тандалт	Фармаковижилансын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх	ЭМБ, ЭХБ, Гадаадын үйлдвэрлэгч, ОУБ
		Хуурамч, стандартын бус, бүртгэлгүй эмийг зах зээлд тандах, илрүүлэх, зах зээлээс эргүүлэн татах үйл ажиллагааг зохион байгуулах	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, ТББ, Гааль, Цагдаа, бусад төрийн байгууллага, ОУБ
		Эмийн талаархи хараат бус, үнэн зөв бодит, мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд түгээх	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, ХЭЗ-ийн салбар зөвлөл, ОУБ
		Зар сурталчилгааны энгийн зөвшөөрөл, зах зээлд таниулах болон зар сурталчилгааны идэвхтэй хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх	ЭМБ, Харилцаа холбоо, Хэвлэл мэдээллийн байгууллага, ХЭЗ-ийн салбар зөвлөл, ЭХБ
		Бичил биетний эсрэг эмийн хэрэглээнд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагатай хамтран ажиллаж зохистой хэрэглээг төлөвшүүлэх	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг, ОУБ
		Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилтэд дүн шинжилгээ хийх	ЭМБ, ОУБ, Төрийн болон ТББ

Дөрөв. Ерөнхий чиг үүрэг: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг лабораторит шинжлэх			
4.1.	Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарыг баталгаажуулах	Фармакопейн хороог ажиллуулж, үндэсний фармакопейг шинэчлэх	Мэргэжлийн зөвлөл, Эмийн үйлдвэр, Судалгаа шинжилгээний байгууллага
		Вакцин, биобэлдмэлийн цувралыг чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх	ОУБ, ЭМБ
		Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт хийх	ЭМБ, СХЗГ, Мэргэжлийн нийгэмлэг, ТББ, ОУБ
Тав. Ерөнхий чиг үүрэг: Эм зүйн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих			
5.1	Эм, эмнэлгийн хэрэгсэл, БИБ-ний чанар, аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, мөрдүүлэх	Эрсдэлд суурилсан мэргэжлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг, ОУБ
		Хяналт шалгалтын үндэсний тогтолцоог бэхжүүлэх	ЭМБ, Орон нутгийн засаг захиргааны нэгж, Төрийн ба ТББ
		Эмнэл зүйн туршилтын хяналт, зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх	ЭМБ, Мэргэжлийн зөвлөл, Судалгаа шинжилгээний байгууллага

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалтаар олон улсын жишигт хүрсэн бүс нутгийн тэргүүлэгч байгууллага болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амыг чанарын баталгаатай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй хангаж, дэвшилтэт технологи бүхий эмнэлгийн хэрэгслийг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж, нотолгоонд суурилсан үнэн бодит мэдээллийг эрүүл мэндийн байгууллага, олон нийтэд түгээж амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
Бүтэц, зохион байгуулалт	
1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 22 дугаар, Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” байгуулагдсан.	Агентлагийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ байна. Тухайлбал: 1. Орон нутаг дах хяналт зохицуулалтын нэгжийн нөөц хангалтгүй.

2. Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор хяналтын чиг үүрэг нэмэгдэж, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн. 3. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг батлагдсан. 4. Байгууллагын соёлыг шинээр бүрдүүлэх боломжтой.	2. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд эмийн хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, эмийн зохистой хэрэглээний талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа тусгагдаагүй. Учир нь байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт нь ДЭМБ-ын зохицуулалтын жишиг тогтоох үнэлгээний (GBT-Global Benchmarking Tool) шалгуурт суурилсан. 3. Зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийн технологийг хөгжүүлэх нэгжгүй. 4. Бусад улсын хяналт, зохицуулалтын байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлээгүй; 5. Эм шинжлэх лабораторийн чадавх сул, техник тоног төхөөрөмж хуучирсан, дутагдалтай.
Төлөвлөлтийн систем	
Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Шинээр байгуулагдсан байгууллагын хувьд төсвийн төлөвлөлтийг бодитой гаргаагүйгээс төсөв хүрэлцээгүй.
Эрүүл мэндийн салбарын эрчимтэй цахим шилжилт хийгдэж байна. Тухайлбал - Эмийн бүртгэл, тусгай зөвшөөрөл, эмийн гаж нөлөөний бүртгэл, эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, эм шинжлэх лабораторийн дотоод үйл ажиллагаанд цахим програмыг ашиглаж байна. - Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагаа И-Монголиа системтэй холбогдсон. - ДЭМБ-ын эмийн аюулгүй байдлын хяналтын хөтөлбөрт 2021 онд нэгдэж, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээллэх цахим системийг ашиглаж байна.	Цахим системд бүртгэгдсэн мэдээллүүдийг харилцан солилцох боломжгүй, нэгдсэн цахим сан байхгүй. Цахим үйл ажиллагааны аюулгүй байдал, хөгжүүлэлт хангалтгүй. ОУ-ын системийг бүрэн ашиглах хангалттай нөөцгүй.
Эм зүйн тусламж үйлчилгээнд хариуцлагатай ил тод байдлыг хангаж, төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлсэн.	Хамтын ажиллагааны хүрсэн үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийдэггүй.
Хяналтын систем	
Дотоод хяналтын журам агентлагийн даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан.	Батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналтыг тогтмолжуулах шаардлагатай. Урьд жилүүдэд хийгдсэн үйл ажиллагааны болон

	төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, шинээр төлөвлөх төсөл арга хэмжээний давхцыг хянах механизм сул
Нөөцийн удирдлага	
Байгууллага өөрийн орлогоор төсвийн 27,9 хувийг бүрдүүлдэг.	Зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг оновчтой төлөвлөхгүй байна.
Ажлын байрыг өөрчилж, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлсэн.	Эм шалгах лабораторийн байргүй, тээврийн хэрэгсэл, ажлын байрны засвар, үйлчилгээнд зарцуулах төсөв, нөөц дутагдалтай.
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын бүтэц, зохион байгуулалтыг нийт 132 орон тоотойгоор баталсан.	Байгууллагын хүний нөөцийн бодлого сул, ажлын байрны шилжилт хөдөлгөөн ихтэй, зарим сул ажлын байранд шаардлага хангасан мэргэжилтэн бүртгүүлдэггүй. Тухайлбал: Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэнгүйгээс гадаад улсын хяналт, зохицуулалтын байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлээгүй байна.
Монгол Улсын 21 аймагт эм, биобэлдмэлийн улсын байцаагч ажиллахаар бүтэц зохион байгуулалт батлагдсан.	Орон нутагт эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, шалгалт хийх нэгжийн хүний нөөц, орон байр, техник хэрэгсэл дутагдалтай;
Төрийн албан хаагчийн сэлгэн ажиллах журмыг хэрэгжүүлж байна.	Ажлын байрны тодорхойлолтыг оновчтой бус. ТАЗ-өөс баталсан зарим ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатай.
Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэн урамшуулдаг.	Нийгмийн баталгааг хангах тал дээр илүү санаачлагатай ажиллах шаардлагатай.
Сургалтын хэрэгцээг тодорхойлж, гадаад болон дотоодын сургалтыг зохион байгуулдаг.	Төрийн албанд мэргэшсэн хүний нөөц тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх, мэргэжилтэнүүдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагыг тасралтгүй дээшлүүлэхэд чиглэсэн зардлын эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгаж, ил тод мэдээлэх, хариуцлагын тогтолцоо сул
Эм зүйн салбарын хүний нөөцийн хариуцлагатай байдлыг хангахад төрийн албаны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, хэм хэмжээ дагадаг.	Салбарын хүний нөөцийн бүртгэл хангалтгүйгээс эм зүйн тусламж, үйлчилгээний шатлал бүрт ажиллаж буй мэргэжилтний үйл ажиллагаа, тэдний мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ мөрдөж байгаа байдалд бүрэн хяналт тавих боломжгүй байна.
Олон улсын байгууллагын хамтын ажиллагаа	
Олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаатай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.	Төсөл, хөтөлбөрийн үр дүнг бодит нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлж чадахгүй. Төсөл, хөтөлбөрийн бодит хэрэгжилт, үр дүнгийн мэдээлэл хүртээмж муутай.

ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
Хууль, эрх зүйн зохицуулалт	
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн.	Хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах хүний нөөц, мэргэшсэн байдал хангалттай бус, хууль тогтоомжийн хэрэгжилт сул. Хяналт, зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх эрх зүйн орчны шинэчлэл удаан явагддаг.
Төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хуулийн хүрээнд хамтран ажиллаж байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх нөлөөлөл, сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр.
Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх, хэрэглээнд гаргах тусгай зохицуулалтыг эрүүл мэндийн сайд болон агентлагийн даргын шийдвэрээр хэрэгжүүлдэг.	Олон улсын нөхцөл байдал, ложистикийн асуудлаас хамаарч эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж доголдож болно. Тусгай зохицуулалтад ОУ-ын удирдамж, сайн туршлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
Нийгэм, эдийн засгийн байдал	
Эрүүл мэндийн байгууллага, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, аяныг зохион байгуулдаг.	Байгууллага, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа бүрэн хангагдаагүй.
Эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар бүх түвшинд анхаарал хандуулж байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, ханган нийлүүлэлт хувийн хэвслээс хэт хамааралтай. Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан чанар, аюулгүй байдлыг хангахад тэдний оролцоо сул Мэргэжлийн төрийн бус байгууллагын чадавхи хангалтгүй.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зорилго: Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүн амыг олон улсын стандартын шаардлагад нийцсэн чанартай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, нотолгоонд суурилсан хараат бус мэдээллийг баталгаажуулан түгээж, үйл ажиллагаандаа дэвшилтэт техник технологи ашиглан олон талт, тогтвортой хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт:

- | | |
|---------------------|--|
| Стратеги зорилт 1: | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлнэ. |
| Стратеги зорилт 2: | Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн ил тод байдлыг хангаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжид нөөцийн мэдээний санг ашиглан дүн шинжилгээ хийнэ. |
| Стратеги зорилт 3: | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй байдлыг хангана. |
| Стратеги зорилт 4: | Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд тавих стандартын шаардлага, импорт, экспортын лиценз олгох шалгуурыг шинэчилж, эмийн эмнэлзүйн туршилтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ. |
| Стратеги зорилт 5: | Эм, эмийн түүхий эд, оношлуурын бүртгэлийн үйл ажиллагаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ. |
| Стратеги зорилт 6: | Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдийг чадавхжуулж, фармаковижилансын үндэсний сүлжээг хөгжүүлнэ. |
| Стратеги зорилт 7: | Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын тандалтыг эрсдэлд суурилан явуулж, хуурамч, стандартын бус эм зах зээлд нэвтрэхээс сэргийлнэ. |
| Стратеги зорилт 8: | Зар сурталчилгааны зөвшөөрөлд тавигдах шаардлагыг тодорхой болгож, хэрэгжилтэд тогтмол хяналт тавина. |
| Стратеги зорилт 9: | Эмийн мэдээллийн хараат бус, бодит байдлыг хангаж, эм, оношлуурын хэрэглэх зааврыг баталгаажуулан эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдэд түгээнэ. |
| Стратеги зорилт 10: | Эм шинжлэх лабораторийн чадавхийг нэмэгдүүлж, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эмийн стандартыг шинэчилж, вакцин, биобэлдмэлийн цувралыг чөлөөлөх ажлыг хэрэгжүүлнэ. |
| Стратеги зорилт 11: | Эм зүйн тусламж, үйлчилгээнд олон улсын стандарт (GMP, GLP, GDP, GSP, GCP, GPP)-ын шалгуурыг ашиглан эрсдэлд суурилсан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлнэ. |

ДОЛОО. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Агентлаг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

Тодорхой: Зохицуулалт, хяналтын зорилго, хамрах хүрээ, тавигдах шаардлага, шийдвэр тодорхой, ойлгомжтой, энгийн, хоёрдмол утга агуулаагүй байх;

Үр ашигтай: Байгууллагын чадавхийг тасралтгүй сайжруулж зохицуулалтын арга хэмжээг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн эрсдэлд суурилсан арга барилаар ажиллах;

Шударга: Үйл ажиллагаандаа нэг талыг баримтлахгүй тэгш, шударга хандах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

Ил тод, нээлттэй: Зохицуулалтын шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, цахим тогтолцоог сайжруулах;

Найдвартай: Санхүүгийн болон мэргэшсэн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах;

Хуульд нийцсэн: Зохицуулалтын үйл ажиллагаа, шийдвэр нь хүний эрхийг хамгаалсан, хууль эрх зүйн үндэслэлтэй байх;


Чандлан нууцлах: Байгууллагын эрх ашиг, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх, төрийн болон хувь хүний нууцыг чандлах;

Уян хатан: Орчин үеийн чиг хандлага, өөрчлөлт, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон улсын болон бүс нутгийн зохицуулалтыг үндэсний чадавхид тохируулан ашиглах, уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэх;

Хараат бус, бие даасан: Хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан шийдвэр гаргадаг байх;

Нотолгоонд суурилсан: Шийдвэр гаргалтад хараат бус мэдээллийн эх үүсвэрийг тогтмол ашиглана.

НАЙМ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Зураг 1. Агентлагийн бүтэц

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/23 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Чанарын хяналтын газар, Захиргаа, удирдлагын газар, Эм хангамжийн газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар, Эмийн бүртгэлийн хэлтэс, Эм үйлдвэрлэлийн хэлтэс гэсэн 6 газар, 2 хэлтэс, 1 эм шинжлэх лаборатори нийт 132 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ЕС.САЛБАР, ХАМТРАГЧ ТАЛ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын хамтын ажиллагааны оролцогч талуудыг доорх зураглалаар харуулав.



Зураг 2. Хамтрагч талууд

Хамтын ажиллагааны чиглэл:

Төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага: Хамтран ажиллах, хууль, тогтоомжийн хүрээнд мэдээ, мэдээлэл солилцох, цахим сан үүсгэх, санал, дүгнэлт, шийдвэр хүргүүлэх.

Хүний эмийн зөвлөл: Төрөөс эмийн талаар баримтлах бодлого; оношлогоо, эмчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн сонголт; үндэсний үйлдвэрлэл, импортын асуудлаар санал, зөвлөмж боловсруулах; эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн, оношлуурыг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, сунгах болон эмийн эмнэлзүйн туршилт судалгаа хийх эсэхийг шийдвэрлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтыг өөрчлөх, хэрэглээнд хяналт тавих чиглэлээр мэргэжлийн зөвлөмж гаргах.

Фармакопейн хороо: Үндэсний болон үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг батлах.

Олон улсын байгууллага: Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүгийн болон техникийн туслалцаа авах.

Сургалт, судалгааны байгууллага: Тасралтгүй сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.

Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, ТББ, иргэний нийгмийн байгууллага: Үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцох

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

Төлөвлөгөөг баталсан:
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

(албан тушаал)

Төлөвлөгөөг боловсруулсан:
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)

Төсвийн Ерөнхийлөн захирагч

/С. ЧИНЗОРИГ/
2024.02.05
(огноо)

Төсвийн Шууд захирагч

/Ш.ЭНХТУЯА/
(огноо)

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024-2027 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2024	2025	2026	2027	
Нэг. Ерөнхий чиг үүргийн нэр: Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах								
Үндсэн чиг үүрэг-1.1: Эмийн зохицуулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох журам, стандарт боловсруулах, шинэчлэх хэрэгжилтийг хангах ажлын зохион байгуулалт								
Зорилт 1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, төрөөс	Арга хэмжээ 1.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хяналт, зохицуулалттай холбоотой эрх зүйн орчныг сайжруулна.	Хууль, журмын төсөлд хүргүүлсэн саналын тоо Батлагдсан журам, стандарт, САЗ	Хуулийн төсөл-10 Батлагдсан журам-8 САЗ-ын тоо-23 Стандартын төсөл-2	Хууль, журам, стандартад 10-аас дээш удаа санал хүргүүлж, 4 журам, 10 САЗ батлуулсан байна.	Хууль, журам, стандартад 15-аас дээш удаа санал хүргүүлж, 5 журам, 8 САЗ батлуулсан байна.	Хууль, журам, стандартад 15-аас дээш удаа санал хүргүүлж, 4 журам, 8 САЗ батлуулсан байна.	Хууль, журам, стандартад, 10-аас дээш удаа санал хүргүүлж, 5 журам, 8 САЗ батлуулсан байна.	Улсын төсөв

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт баримтах бодлогыг хэрэгжүүлнэ.	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2024	2025	2026	2027	
	Арга хэмжээ 1.2 Дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	Байгууллагын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-80	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-80	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийхэд бэлэн болсон байна. ДЭМБ болон ОУБ-ын дэмжлэгтэйгээр байгууллагын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх нөхцөл бүрдсэн байна.	Улсын төсөв ОУБ-ын төсөл, хөтөлбөр
	Арга хэмжээ 1.3. Бүсийн эсвэл бусад орны эмийн зохицуулалтын байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж зохицуулалтын шийдвэр гаргалтад итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлнэ.	Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамж (GRP) ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо-9	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамжийг хэрэгжүүлэх бусад улсын эмийн зохицуулалтын байгууллагын талаар судалж, итгэлцлийн зохистой дадлын удирдамжийг орчуулж, гарын авлага гаргасан байна.	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамжийг зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж, бусад орны нэг байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна.	ДЭМБ-ын итгэлцлийн зохистой дадлын удирдамжийг хэрэгжүүлсэн зохицуулалтын шийдвэрт дүн шинжилгээ хийсэн байна.	Бүсийн эсвэл бусад орны эмийн зохицуулалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр
	Арга хэмжээ 1.4. ОУ-ын удирдамж, стандартын дагуу эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын	Дотоод болон гадаад үнэлгээний үр дүн Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Ажлын хэсэг Батлагдсан чанарын гарын авлага	Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, гарын	Дотоод болон гадаад үнэлгээ хийлгэж, эрсдэлд суурилсан чанарын удирдлагын тогтолцоог	Байгууллагын үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрсэн байна.	Байгууллагын үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрч оролцогч талуудын хамтын	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин				Санхүү гийн эх үүсвэр
				2024	2025	2026	2027	
	тогтолцоог нэвтрүүлнэ.		Гадаад сургалтад хамрагдсан хүн-2	авлага боловсруулан хүний нөөцөө чадавхжуулсан байна.	нэвтрүүлсэн байна.		ажиллагаа бэхжсэн байна.	
	Арга хэмжээ 1.5. Эм зүйн салбарын сайн засаглал (Эм зүйн салбарын үзүүлэлт, зохицуулалтын үйл ажиллагааны мэдээлэл, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн хувь)-ыг бэхжүүлж, ил тод байдлыг хангана.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг судалсан судалгааны дүн	Сэтгэл ханамжийн судалгааны шалгуур асуумж Статистик мэдээлэл цуглуулах батлагдсан маягт Сэтгэл ханамжийн судалгааны дүн- 3.9	Ажлын хэсэг байгуулсан байна. Сэтгэл ханамжийн судалгааны дүн 3.9- ээс дээш гарсан байна.	Сэтгэл ханамжийн судалгааны шалгуур асуумж, статистик мэдээлэл цуглуулах маягтыг батлуулсан. Сэтгэл ханамжийн судалгааны дүн 3.9-ээс дээш гарсан байна.	Эм зүйн салбарын үзүүлэлтийг батлагдсан маягтын дагуу мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, гаргасан байна. Сэтгэл ханамжийн судалгааны дүн 3.9-ээс дээш гарсан байна.	Эм зүйн салбарын үзүүлэлтийн мэдээллийг үндэсний статистик мэдээлэлтэй холбосон байна. Сэтгэл ханамжийн судалгааны дүн 3.9-ээс дээш гарсан байна.	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр
	Арга хэмжээ 1.6. Хүний нөөцийн хөгжлийн тогтвортой байдлыг хангана.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Зохицуулалтын үйл ажиллагааны чиглэл бүрийг тусгасан сургалтын нэгдсэн төлөвлөгөө	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 94 хувь хэрэгжүүлсэн. Эм зүйн салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө 90 хувьтай хэрэгжүүлсэн.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хэрэгжүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 90- ээс дээш хувь хэрэгжүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 90- ээс дээш хувь хэрэгжүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хэрэгжүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 95 хувиас дээш хэрэгжүүлсэн байна.	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2024	2025	2026	2027	
	Арга хэмжээ 1.7. Санхүүгийн төлөвлөлтийг оновчтой хийж, ил тод байдлыг хангаж ажиллана.	Шилэн дансанд байршуулсан мэдээлэл Төсөл хөтөлбөрийн санхүүжилт	Шилэн дансанд байршуулсан мэдээлэл-12 Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр-9	Төсвийн төлөвлөлтийг үйл ажиллагаатай уялуулж, холбогдох мэдээлэл, тайланг тогтмол цаг хугацаанд нь ил тод байршуулсан байна.	Төсвийн төлөвлөлтийг үйл ажиллагаатай уялуулж, холбогдох мэдээлэл, тайланг тогтмол цаг хугацаанд нь ил тод байршуулсан байна.	Төсвийн төлөвлөлтийг үйл ажиллагаатай уялуулж, холбогдох мэдээлэл, тайланг тогтмол цаг хугацаанд нь ил тод байршуулсан байна.	Төсвийн төлөвлөлтийг үйл ажиллагаатай уялуулж, холбогдох мэдээлэл, тайланг тогтмол цаг хугацаанд нь ил тод байршуулсан байна.	Улсын төсөв ОУБ-ын төсөл, хөтөлбөр
	Арга хэмжээ 1.8. Эмийн зохицуулалтын үйл ажиллагааны нэгдсэн цахим тогтолцоог бүрдүүлнэ.	Нэгдсэн цахим программ Цахим үйлчилгээний тоо	Tzmoh.gov.mn Licemed.mohs.gov.mn EMongolia Burtgel.mohs.mn Heps.hdc.gov.mn Ereporting Lims программ	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй цахим программын уялдааг хангаж, нэгдсэн цахим тогтолцооны төслийг боловсруулсан байна.	Нэгдсэн цахим программын нэгжийн бүтцийг бий болгож, цахим программын тогтвортой ажиллагааг хангасан байна.	Нэгдсэн цахим программын ажиллагааг үнэлсэн байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын бүртгэл, хяналтын нэгдсэн цахим тогтолцоо бүрдсэн байна.	Улсын төсөв ОУБ
Үндсэн чиг үүрэг-1.2. Зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг нэмэгдүүлж, үнийн ил тод байдал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа								
Зорилт 2. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн ил тод байдлыг хангаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжид нөөцийн мэдээний санг ашиглан дүн шинжилгээ хийнэ.	Арга хэмжээ 2.1. Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Цахим дэлгүүрт нэмэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл	Цахим дэлгүүрт 143 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршсан.	Цахим дэлгүүрт 15-аас дээш нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэмсэн байна.	Цахим дэлгүүрт 20-оос дээш нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэмсэн байна.	Цахим дэлгүүрт 20-оос дээш нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэмсэн байна.	Цахим дэлгүүрт 20-оос дээш нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нэмсэн байна.	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр
	Арга хэмжээ 2.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нэгдсэн цахим	Хангамжийн нэгдсэн цахим мэдээний сан	burtgel.mohs.mn цахим систем	Эмийн үнэ, хангамж, нөөцийн мэдээлэл солилцох программын	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нэгдсэн цахим	Нэгдсэн цахим сангийн ашиглалтад үнэлгээ хийсэн байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үнийн ил тод	Улсын төсөв, ОУБ-ын төсөл, хөтөлбөр

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин				Санхүүгийн эх үүсвэр
				2024	2025	2026	2027	
	мэдээний сан бүрдүүлж, эмийн үнийн ил тод байдлыг хангана.			хөгжүүлэлтийг эхлүүлсэн байна.	сан ашиглаж эхэлсэн байна.		байдлыг хангана.	
Зорилт 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй байдлыг хангана.	Арга хэмжээ 3.1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын хийх эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрлийн тоо Хамрагдсан байгууллагын тоо	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрлийн тоо-13 Хамрагдсан байгууллагын тоо-169	Хамрагдсан байгууллагын тоо 10-аар нэмэгдсэн байна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрлийг 16 болгосон байна. Хамрагдсан байгууллагын тоо 10-аар нэмэгдсэн байна.	Хамрагдсан байгууллагын тоо 10-аар нэмэгдсэн байна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрлийг 19 болгосон байна. Хамрагдсан байгууллагын тоо 10-аар нэмэгдсэн байна.	Улсын төсөв, ОУБ-ын төсөл хөтөлбөр
